

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

20 ~~25~~ оны ~~12~~ сарын ~~05~~ -ны өдөр

№ ~~25~~

Улаанбаатар хот

Салбар нэгж шинээр байгуулах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, “Сэндли ББСБ” ХК (цаашид “Компани” гэх)-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.6.25 дэх заалт, 14 дүгээр зүйлийн 14.6.9 дэх заалтыг тус тус үндэслэн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаас **ТОГТООХ нь:**

1. “Сэндли ББСБ” ХК нь салбарын үйл ажиллагааг өргөтгөх зорилгоор Говь-Алтай аймгийн Есөнбулаг суманд салбар нэгж шинээр байгуулсугай.
2. Шинээр байгуулах салбар нэгжийн хаягийг Монгол Улс, Говь-Алтай аймаг, Есөнбулаг сум, Оргил баг, 13-р гудамж, 22А тоот, үйлчилгээний төвийн I давхарт байхаар тогтоосугай.
3. Компанийн дүрэмд заасны дагуу салбар нэгжийн удирдлагыг томилохыг Гүйцэтгэх захирал /Б.Одгэрэл/-д зөвшөөрсүгэй.
4. Салбар нэгжийг шинээр байгуулахтай холбоотойгоор түрээсийн гэрээ байгуулах, эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авах, улсын бүртгэлд бүртгүүлэх ажлыг зохион байгуулахыг Гүйцэтгэх захирал /Б.Одгэрэл/-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Б.НАРАНБАТ

